



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2024.03.29 № 03/806

танай _____-ны № _____-т

**АЙМАГ, ДҮҮРГИЙН ХАБЭА-Н
ЗӨВЛӨЛ, ЯАМДЫН ХАБЭА-Н
САЛБАР ХОРООНД**

**Сарын аян зохион байгуулах
тухай**

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” болгон олон улсын хэмжээнд тэмдэглэж байхаар 2003 онд шийдвэрлэсэн.

Манай улс 2012 оноос эхлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян өрнүүлж, тус аяны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг олон арга хэмжээ зохион байгуулсаар ирсэн.

Энэ жил Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө” уриаг гаргасан байна.

Иймд бид “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян- 2024” арга хэмжээг Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан уриатай уялдуулан “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриан дор зохион байгуулахаар ажиллаж байна.

Дээрх ажлын хүрээнд байгалийн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлээс /хүчтэй салхи шуурга, хар салхи, үер, цас, зуд, ган гачиг, их хэмжээний бороо, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/ урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалах зэрэг арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, цахим орчин, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах ажлуудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

-Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан дээрх уриатай уялдуулан жилийн дөрвөн улирлын эрс тэс уур амьсгалын гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нь ихэвчлэн хөдөө орон нутгийн малчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг тул үүнээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

-Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн халуунаас үүдэлтэй стресс, бухимдал, нарны хэт ягаан туяа, агаарын бохирдол, томоохон үйлдвэрлэлийн осол, цаг агаарын эрс тэс байдал, халдварт өвчин, химийн бодисын нөлөөнд өртөхөөс урьдчилан сэргийлэх;

-Нийт ажил олгогч эздэд зориулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон Хөдөлмөрийн хууль тогтоомжоор хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэхийг уриалах, зөвлөмж гарган сурталчлах;

-Хүүхэд, залуучууд, малчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох сурталчилгааны ажлыг зохион байгуулах /гэр, сургууль, цэцэрлэг, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх/;


-Малчдад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлагыг түгээх, сурталчлах зэрэг олон талт нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян - 2024” арга хэмжээг аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, яамдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан хамтран зохион байгуулж ажиллана уу.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян зохион байгуулсан ажлын тайлангаа 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд ирүүлнэ үү.

Хувийг: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд цахимаар хүргүүлэх болно.

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АЛИМАА

